



**ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН САНГИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.2, Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.4.1, 2.4.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шинжлэх ухаан, технологийн сангийн ажилтан, албан хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаа, хоорондын харилцаа, уялдаа холбоог сайжруулах, ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх ажлын хүрээнд ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Санхүүгийн аудитор

Оюуны өмч, бизнес хөгжлийн мэргэжилтэн

2. Ёс зүйн зөвлөл байгуулагдсантай холбогдуулан сангийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн журмыг нэгдүгээр, ёс зүйн зөвлөлийн хурлын тэмдэглэлийн загвар маягыг хоёрдугаар, зөвлөлийн хурлын тогтоолын загвар маягыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан журмын хэрэгжилтэд хяналт тавих эрхийг өөрт үлдээсүгэй.

ЗАХИРАЛ



М.ТУНГАЛАГ

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Шинжлэх ухаан, технологийн сангийн (цаашид "Сан" гэх)-ийн ажилтан, албан хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагч, иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 122 дугаар тогтоолоор тогтоосон хэм хэмжээ, зарчим нь Шинжлэх ухаан, технологийн сангийн ажилтан, албан хаагчийн ёс зүйн дүрмийн хууль, эрх зүйн үндэс болно.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журам нь Шинжлэх ухаан, технологийн сангийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нийт ажилтан, албан хаагчид, гэрээт ажилтан болон холбогдох бусад асуудлаар хамтран ажиллаж буй аж ахуй нэгж байгууллага, төрийн албан хаагчид хамаарна.

Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. "Ажилтан, албан хаагч"- Ажил олгогчтой хөдөлмөрийн хугацаатай, хугацаагүй, түр болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар гэрээ хэлцэл хийсэн иргэн

3.2. "Хүчирхийлэл"- Хүч, эрх мэдлээр давамгайлж, бусдын дургүйцлийг хүргэх, дарамтлах, доромжлох, айлган сүрдүүлж бие болон сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хувьд хохирол учруулж буй бүх тааламжгүй үйлдэл

3.3. "Ялгаварлан гадуурхалт"- Дараах үндэслэлүүдээр ямар нэг хүнийг ялгаварлан гадуурхахыг ойлгоно: нас, хүйс, арьс өнгө, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал, ХДХВ/ДОХ-ын статус, жирэмсэн эсэх, бэлгийн чиг хандлага, нийгэмд эзлэх байр суурь, эцэг эхийн статус, гэрлэлтийн байдал, намын харьяалал, улс төрийн үзэл бодол, албан тушаал, эрх мэдэл г.м

3.4. "Бэлгийн дарамт"- Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлэх, уриалан дуудах, санал болгох, өдөх, эсхүл бэлгийн харилцаанд орохоос аргагүй байдалд оруулах, бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох, үр

дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, албадан тулган шаардах байдлаар нэр төр, эрх чөлөө, хувийн халдашгүй байдалд халдах үйлдэл

3.5. “Нэр төрийг гутаан доромжлох”- Бусдыг үзэн ядах, атаархах, өсөрхөх байдлаар нэр төрд нь халдах, доромж үг хэллэг хэрэглэх, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр доромжлох, худал мэдээлэл тараахыг ойлгоно

3.6. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил”- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг

Дөрөв. Ажилтан, албан хаагчдын харилцаа эрх, үүрэг

4.1. Байгууллага нь ажилтан, албан хаагч бүрийн эрх ашгийг эрхэмлэсэн, найрсаг хүндэтгэлтэй харилцааг бий болгох, ажилтан бүрт эрх тэгш хандах, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дээрэлхэн сүрдүүлэлт, гүтгэлгээс ангид, аюулгүй байдалд ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2. Ажилтан, албан хаагч нь:

4.2.1. Үндэс угсаа, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаварлан гадуурхах, нэр төрийг гутаан доромжлох, дээрэлхэн сүрдүүлэх, гүтгэхээс ангид байх

4.2.2. Хэл амаар доромжлох, заналхийлэх, доог тохуу хийх, үйл хөдлөлөөр тохуурхах зэргээр ажил үүргээ хэвийн явуулахад саад тотгор, аливаа дарамт шахалт үзүүлэхгүй байх

4.2.3. Бүдүүлэг зан авир гаргах, бусадтай зүй бусаар харьцах болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулахгүй байх

4.2.4. Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй, худалдан борлуулахгүй байх

4.2.5. Ажил хэрэгч бус, этгээд байдлаар хувцаслахгүй байх

4.2.6. Ажлын байранд галт зэвсэг, хутга мэс авчрахгүй байх

4.2.7. Аливаа хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх

4.2.8. Бодит бус, худал, үндэслэлгүй мэдээллийг гадагш түгээх, бусад байгууллага хувь хүнд тараахыг хориглоно. /Хувь хүний нууцын тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан бусад нууцтай холбоотой асуудлыг ойлгоно/

4.2.9. Албан тушаал, эрх мэдлийн хэмжээгээр бусдыг ялгаварлахгүй байх

4.2.10. Төрийн албаны захирах, захирагдах ёсыг эрхэмлэж байх

4.2.11. Ажлын байранд бусдын зөвшөөрөлгүй эсхүл мэдэгдэлгүйгээр гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийхийг хориглоно

4.2.12. Ажлын байранд өөрийн ажил үүргийн хуваарийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж буй ажилтны ажилд саад учруулах болон бусад байгууллага, хувь хүний хажууд зохисгүй буюу хоорондоо муудалцах, бүдүүлэг зан авир гаргах, бусадтай зүй бусаар харьцахыг хориглоно

4.2.13. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д заасан бусад харилцаа

Тав. Ажилтан, Албан хаагчдын ёс зүйн

зөрчлийг хянан шийдвэрлэх

5.1. Шинжлэх ухаан, технологийн сангийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хэлтсийн дарга нар тус тусын чиглэлээр хяналт тавьж ажиллана.

5.2. Албан хаагчдын ёс зүйн зөрчлийг Шинжлэх ухаан, технологийн сангийн дэргэдэх ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэнэ.

5.3. Ажилтан, албан хаагч ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

5.4. Тухайн албан хаагчийн дээд шатны албан тушаалтан, эсхүл уг байгууллагын ёс зүйн зөвлөл гомдол, мэдээллийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор дараах журмын дагуу шалгалт явуулна:

5.4.1. гомдол, мэдээлэлд холбогдсон албан хаагч болон гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдгээрийн тайлбар, саналыг сонсож, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг авах тэмдэглэл хөтлөх;

5.4.2. шаардлагатай гэж үзвэл бусад байгууллагаас баримт бичиг, тайлбар, бусад лавлагаа материалыг гаргуулж авах;

5.4.3. харьяалах нэгжийн удирдлага, албан хаагчидтай уулзаж, шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах.

5.5. Албан хаагчдын ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 122 дугаар тогтоолын дагуу явуулна.

Зургаа. Сангийн ёс зүйн зөвлөл

6.1. Ажилтан, албан хаагч нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий Шинжлэх ухаан, технологийн сангийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл (цаашид “Ёс зүйн зөвлөл” гэх) ажиллана.

6.2. Ёс зүйн зөвлөл нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Шаардлагатай тохиолдолд 2 гишүүнийг ёс зүйн зөвлөлийн хүсэлтээр оролцуулж болно.

6.3. Ёс зүйн зөвлөл энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд ажиллана.

6.4. Ёс зүйн зөвлөл нь ажилтан, албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг энэ дүрмийн 5 дахь хэсэгт заасны дагуу шалгаж ирүүлсэн танилцуулга, материалыг хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн

шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид энэ дүрмийн 7.2-т заасан хариуцлагыг хүлээлгэх тогтоол гаргана.

6.5. Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор энэ дүрмийн 7.2.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд уучлал гуйх хэлбэрийг тодорхойлсон байна.

6.6. Ёс зүйн зөвлөлийн хуралдаанд гомдол, мэдээллийг шалгасан албан тушаалтан болон ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.

6.7. Ёс зүйн зөвлөлийн тогтоолыг зөрчил гаргасан албан хаагчид танилцуулна.

6.8. Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.

6.9. Сангийн удирдлага ёс зүйн зөвлөлийн ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Долоо. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

7.1. Холбогдох хууль, энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэл нь түүнд Хөдөлмөрийн тухай хууль, журам, дүрэмд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

7.2. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн ажилтан, албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан Ёс зүйн зөвлөл ёс зүйн дараах хариуцлага хүлээлгэнэ:

7.2.1. уучлал гуйхыг үүрэг болгох;

7.2.2. сануулах;

7.2.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 40, 131 дүгээр зүйлд тус тус заасан зарим арга хэмжээг авах тухай саналаа ажил олгогчид хүргүүлэх /шаардлагатай тохиолдолд/

7.3. Ажилтан, албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд үйлдэлдээ дүгнэлт хийж, сайн дураараа албан тушаалаас чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.

7.4. Ажилтан, албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

7.5. Сахилгын шийтгэлийг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрэм болон бусад холбогдох дүрэм, журамд заасны дагуу захирлын тушаалаар оногдуулж сахилгын шийтгэл оногдуулсан тухай тушаалыг тухайн ажилтан, албан хаагчид танилцуулж хувийн хэрэгт хавсаргана.

Найм. Хяналт хариуцлага

8.1. Энэхүү дүрмийн хэрэгжилтэд ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан буюу Сангийн захирал хяналт тавьж ажиллана.

8.2. Ёс зүйн зөвлөлөөс гаргасан тогтоолыг үндэслэн ажилтанд Захирлын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулж болно.

8.3. Ёс зүйн зөрчил нь гэмт хэргийн болон авлигын шинжтэй бол холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.

Шинжлэх ухаан технологийн сангийн
захирлын 2019 оны 11 сарын
13 өдрийн А/46 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

20...оны.....сарын....ны өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Хаана, хэзээ:

Хуралд:

Хэлэлцсэн нь:

Сонссон нь:

Шийдвэрлэсэн нь:

Тэмдэглэл хөтөлсөн:

/гарын үсгийн тайлал/

Хянасан:

/гарын үсгийн тайлал/

Шинжлэх ухаан технологийн сангийн
захирлын 2019 оны 11 сарын
13 өдрийн А/У дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САНГИЙН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20...оны...сарын...ны өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Хууль, засгийн газрын тогтоол, шийдвэр, холбогдох бусад дүрэм, журам, заавар:

Тогтоол гарахад нөлөөлсөн баримт нотолгоо дурдсан байх

Даалгасан эсэх, бусад мэдээлэл

Шийдвэрлэсэн зөвлөлийн

гишүүдийн гарын үсэг:

/гарын үсгийн тайлал/